

## УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ХЯТАДААС ЗҮҮН ӨМНӨД АЗИД ЯВУУЛЖ  
БОДЛОГО:ЭРТ, ЭДҮГЭЭД****Э. Пунцаг  
Ч. Сувд**

Он жил улирахад алив улсын тухайн үедээ цаг үеийн гэгдсэн асуудал цагаа өнгөрөөж, оронд нь шинэ асуудал гарч байдаг нь нийтлэг үзэгдэл юм. Гэвч хятадаас Зүүн өмнөд Азид явуулж байгаа бодлого он жил өнгөрөх тусам огоорогдох биш харин ч хуучин хэвээр үргэлжилж, тэгэх тэгэхдээ ул язгууртаа бүр хэдэн зуун жилийн тэртээх феодалын үеийн хятадын «хятад төв»-ийн бодлогыг өвөлсөнөөрөө онцлогтой юм. Нөгөө талаар Зүүн өмнөд Азийн улс орнуудын хувь заяа, тэнд гарч буй хувьсгалт өөрчлөлтийг дэлхийн олон нийт анхааралтай ширтэн харж байна. Энэ нь аргагүй хэрэг. Дэлхийн II дайны дараа шинэ тулгар тусгаар тогтносон Зүүн өмнөд Азийн улс түмний цаашдын амжилт, империализмын эсрэг, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд тэдний эзэлж буй байр суурь, гүйцэтгэж буй үүрэг маш их бөгөөд чухал ач холбогдолтой байсаар ирэв.

Далаад оны Ази дахь хувьсгалт хөдөлгөөний томоохон амжилтын нэг бол Энэтхэг-Хятадын хойгийн гурван улс (Вьетнам, Лаос, Кампучи) эрх чөлөө, тусгаар тогтнолоо бататгаж социалист хувьсгалын замаар орсон явдал юм. Гэтэл Ази дахь дэлхийн хувьсгалт хөдөлгөөний ийм өрнөлтийн эсрэг АНУ, Хятад хоёр үнэн хэрэг дээрээ хуйвалдсаныг АНУ-ын шууд ивээлийн дор хятад 600 мянган хүнтэй армийн хүчээр 1979 онд Вьетнамд халдан довтолсон хэрэг явдал харуулсан билээ.

Зүүн өмнөд Азийн орнуудын ард түмний хувь зохиол түүхийн эрт үеэс тухайлбал, хожуу палеолитын үеэс хойш ижил төстэй соёл иргэншлээр холбогдож ирсэн бөгөөд сүүлийн 100 гаруй жилийн турш (XIX зууны II хагасаас XX зууны II хагас хүртэл) Франц, Америк, Япон зэрэг империалист гүрний колончлол, шинэ колоничлолын эсрэг хамтарч тэмцсэн зэрэг олон онцлогтой юм. Ялангуяа, энэтхэг-хятадын хойгийн гурван улсын хувьсгалт тэмцлийн түүх нь энэ талаар нягт холбоотой явж ялалтанд хүрч ирсэн түүхтэй учраас тэдгээрийн өнөөгийн харилцаа нь тухайн тодорхой нөхцөлд онцгой байхаас өөр замгүй. 1982 онд хуралдсан Вьетнам-Лаос-Кампучийн тусгай харилцааг гурван орны хувьсгалын хөгжилтийн зүй тогтол, гурван ард түмний хувь заяаны нэн чухал ач холбогдол бүхий зүйл гэж тодорхойлсон байна.<sup>1</sup>

ЗХУ-д Зүүн өмнөд Азийн судлалын үндсийг тавигч бөгөөд зохион байгуулагч, академич А. А. Губер уг районы ард түмний эрх чөлөө-

<sup>1</sup> “Vietnam courier”, A Monthly Review. vol. XVIII N 5, 1982. P. 12.

ний хөдөлгөөний хөгжилтийн түүхийг колониололын түүх судлалтай салшгүй холбоотой авч үзэхийг чухалчилж байсан бол мөн тэгж үзэхийн зүйтэйг сүүлийн үед францын Г. Кондоминас зэрэг өрнөдийн зарим судлаачид ч хүлээн зөвшөөрч байна. Энэтхэг-хятадын хойгийн улсууд умард хөрш хятадын феодалын үеийн улс, түүний гар хөл бологчдын булаан эзлэлтийн эсрэг олон зуун жилийн турш тэмцсээр иржээ.

Эртний Цинь улсын эзэн Цинь Шихуанди манай эриний өмнөх 214 онд Вьетнамд анх довтолсон боловч амжилт олоогүй буцсан ба зуун жилийн дараа хятадын хан улс бас довтолж, түүнээс хойших үед ч Вьетнамыг мөн л эзэлж эрхэндээ оруулах бодлого явуулж байжээ. Урьд Сиам гэдэг байсан одоогийн Тайланд ч хэзээнээс нааш зарим үед Хятадын түлхээсээр, зарим үед биеэ дааж Лаос, Кампучи, Вьетнамд довтолсоор иржээ. Бээжингийн өнөөгийн эрх баригчдаас Вьетнамын талаар явуулж буй бодлого цаг үе, шалтгийн хувьд ялгаатай боловч агуулга, зорилгын хувьд хятадын эртний хаадын эзлэн түрэмгийлэх бодлогын ерийн үргэлжлэл болж байна. Энэ нь хятад улстай олон мянган жил хөрш зэргэлдээ оршиж, түүхэн үед хятадын дорно, өмнөдийн аян дайнд хөлд хутгалдаж явсан орны түүх гадарлах жирийн хүний ойлголт төдийгүй, өнөөгийн соёлт ертөнцийн шударга хүн олны ойлголт болж байна. Тийм хүмүүс хятадын өнөөгийн бодлогыг бүр 60—70-аад онд тодорхой бичиж байсан юм. Хятадад 1929—1939 ба 1946—1950 онд ажиллан амьдарч, дараа нь 1956, 1958 онд очиж байсан Австралийн үндэсний их сургуулийн Алс Дорнодын түүхийн профессор К. П. Фитцджеральд 1969 онд бичихдээ: «хятадын дээр үеийн хувьсгалчид болон реформистуудын дэвэргэж байсан «хятадыг амьлуулах» хөдөлгөөний үргэлжлэл болгон номнож байгаа хятадын эзэнт улсын оргил болсон үеийн байдал, түүний түүх дэвсгэр нутгийг дахин эзэмших явдал бол хятадын гадаад бодлогын нэг зорилго»<sup>2</sup> гэсэн бол түүнээс 10 жилийн дараа хөрш Энэтхэгийн улс төрийн зүтгэлтэн, дипломат Р. С. Чаван «хятадын гадаад бодлого: Чжоу Энхлайн эрин үе» гэдэг номдоо дээрх шинж чанарыг нэлээд тодруулж хятадын гадаад бодлого нь хятадын эртний эзэнт улсын хилийг сэргээх, Ази дахь түүний уламжлалт нөлөөг тогтооход оршиж байна гэжээ.<sup>3</sup>

Хил хязгаараа тэлэх, «алдагдсан дэвсгэр» нутгаа эргүүлэн авах тухай хятадын удирдагчдын өөрсдийн нь удаа дараа хэлсэн үг ном хэвлэлд өргөн тусгагдсан байдаг. Зүүн өмнөд Азийн талаар тэдний хэлсэн үг ч нэгэн адил тийм юм. Харин «Ази дахь хятадын ирээдүйн байр суурь» гэдэг сэдвээр 1983 оны 4-р сард Токио-д болсон хятад, японы судалгааны симпозиум дээр хятадын Олон улсын харилцааны институтын орлогч захирал Пэй Монуну хэлсэн үгийг энд иш татахад илүүдэхгүй бололтой. Тэр илтгэлийнхээ 3 дахь зүйлийг «Зүүн өмнөд Азид жанжлалаа тогтоох гэсэн Вьетнамын оролдлогыг эрс эсэргүүцэе» гэж илэн далангүй нэрлээд төгсгөлд нь «Вьетнам Кампучийг эзэлснийг» «*Fait accompli*»<sup>\*</sup> гэж хүлээн зөвшөөрөх нь Вьетнам Зөвлөлтөөс гараа суллахын хариу болох ба энэ нь мөн хятадын «өмнө зүг давшихыг» зогсооно гэж үздэг хандлага зарим оронд байгаа нь тун аюултай юм. Хятад ямар ч түрэмгий санаархал өвөрлөөгүй. Ингэж

<sup>2</sup> C. R. Fitzgerald. The Chinese view of their Place in the world, Oxford University Press, London, Oxford, New York, 1969, p. 68-69

<sup>3</sup> R. S. Chavan. Chinese Foreign Policy: The Chou Enlai Era. Sterling Publishers New Delhi, 1979. P. 62

\*«Нэгэнт гүйцсэн хэрэг»

бодож байгаа орнууд өөрсдөө хохирох болно гэсэн эгзэгтэй үг хэлсэн байна.<sup>4</sup> Гэвч хэн нь хэнийгээ яаж хохироох тухай яригдаж буй нь К. П. Фитцджеральд, Р. С. Чаван нар болон тэдний ижил сэтгэх хүн бүхэнд тов тодорхой юм.

Империализм, колониололын талхинаас энэтхэг-хятадын хойгийн ард түмнийг эцсийн бүлэгт аварсан гол хүч бол Орост ялсан социалист хувьсгалаар эх суурь нь тавигдсан дорнодахины ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлт бөгөөд түүний нэг жигүүрийг удирдан зохион байгуулагч Зүүн өмнөд Азид анхны эрх баригч нам болсон коммунист нам 1930 онд Вьетнамд байгуулагдсан энэ хоёр хүчин зүйл юм.

«Хэрэв Оросын большевикууд хуучин империализмыг цохиж хувьсгалын шинэ замыг бий болгох ер бишийн хүнд бэрх боловч, ер бишийн сайхан зорилтыг хүлээн аваад байгаа бол Дорно дахины хөдөлмөрчин олны төдөөлөгч та бүхэнд бүр ч их, бүр ч шинэ зорилт оногдох болно»<sup>5</sup> гэж 1919 оны 11-р сарын 22-нд Бүх оросын дорнодахины ард түмний коммунист байгууллагуудын их хуралд тавьсан илтгэлдээ В. И. Ленин тэмдэглээд Дорнодахины коммунист байгууллагуудын зорилт бол социалист хувьсгалын зөвхөн тухайн оронд явуулаад зогсох биш түүнийг бүх колони болон хараат орнуудаас олон улсын империализмын эсрэг хийх тэмцэл болгон өрнүүлэхийн чухлыг заасан юм. Тэр юуны өмнө дорно дахины хувьсгалт тэмцлийг олон улсын империализмын эсрэг явуулж буй Зөвлөлт улс, оросын коммунистуудын тэмцэлтэй нэгтгэхийг чухалчилж байв.<sup>6</sup>

Азийн нөлөө бүхий том гүрэн БНХАУ олон улсын империализмын эсрэг ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орнууд, олон улсын коммунист, ажилчны намуудын тэмцэлтэй нийлж нягтрах замаас өнөө үед ухраад буй нь харамсалтай юм. Гэвч олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөнтэй хувь заяагаа нягт холбож империализм, шинэ колониололын эсрэг тэмцэлдээ ямар түүхэн ялалт байгуулж болохыг энэтхэг хятадын хойгийн ууган социалист орон—Вьетнамын туршлага харуулж байна. Энэ хойгийн өөр нэг бүрэн эрхт улс БНКАУ-д хувьсгал бэхжин хөгжих явцад Бээжингийнхэн саад учруулсаар байна.

Кампучийг сайндаа л төвийг сахисан нэртэй боловч хэрэг дээрээ Хятадыг дагасан, заавал марксист биш, олон намын системтэй ийм л улс болгохыг Хятад эрмэлзэж байгаа тухай өрнөдийн хэвлэлд Дэн Сяопин, Чжао Цзыян нарын мэдэгдэлд тулгуурлан бичиж байна.<sup>7</sup> Гэвч ард түмэн сонгож авсан замаасаа ухрахыг хүсэх үү дээ!

Кампучийн харгис бүлгийнхэнээс бүрдсэн «Ардчилсан Кампучийн эвслийн засгийн газар» гэгч нь 1982 оны 6-р сарын сүүлчээр Бээжингийн идэвхтэй оролцооны дүнд эмхлэн байгуулагдсан юм. Түүний гол зорилго нь Кампучийн эх оронч хүчийг эсэргүүцэх, социалист Вьетнамд дарамт шахалт үзүүлэхэд чиглэгдсэн, хэрэг дээрээ Пол Потын өнгөө далдалсан дэглэм гэсэн үг юм. Ийм учраас түүнийг хятадын тал цэрэг, зэвсэг, хөрөнгө мөнгөөр хичнээн тэтгэх тусам, уг бүс нутгийн эгзэгтэй асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэхэд тус үзүүлж чадахгүй, гагцхүү хор хүргэх нь мэдээж билээ. Гэтэл хятадын засгийн газар кхмерийн харгис хүчний 30,000 шахам хүнтэй цэргийг өнөө хүртэл зэвсэгийн хүчээр дэмжсээр байна.

70—80 –аад оны зааг дээр хятадын гадаад, дотоод бодлогод дэлхийн олон нийтийн анхаарлыг хөндсөн зарим үйл явдал болсны нэг нь

<sup>4</sup> «Бээжин ревью» 1983. 4. 18 (англи хэл дээр)

<sup>5</sup> В. И. Ленин. Зохиолууд. IV хэвлэл, 30-р боть, 143 дахь тал.

<sup>6</sup> Мөн тэнд. 144 дэх тал.

<sup>7</sup> Asian Survey. vol. XXIII. No 5, May, 1983. P. 604-605

ХКН-ын Төв Хорооны 11 дэх удаагийн 3-р бүгд хурал юм гэж хэлж болно. 1978 оны 12-р сард хуралдсан энэ бүгд хурлаас хятад, японы энх тайван, найрамдлын гэрээ байгуулсан хийгээд хятад, АНУ-ын харилцааг хэвийн болгох хэлэлцээ явагдаж дууссан нь Ази тив болоод даян дэлхийн энх тайвны үйлсэд «чухал хувь нэмэр» боллоо гэж тэмдэглэсэн байна. Гэтэл өнөөгийн үнэн байдал огт өөр зүйлийг харуулж байна. Ази тивээс зөвхөн Энэтхэг-Хятадын хойгийн байдлыг аваад үзэхэд энэ районоос арваадхан жилийн өмнө зайлсан Америкийн ролийг одоо Хятад гүйцэтгэх нь үү гэдэг болгоомжлолыг Зүүн өмнөд Азийн улс орнуудад төрүүлж байна. Кампучаас Вьетнамын цэргийг гаргаад оронд нь хятадын талыг баригч цэргээр дүүргэх Хятадын бодлогын талаар «фар истерн экономик ревью» сэтгүүл саяхан бичжээ.

Зүүн өмнөд Азид «социализмын аюул» «зөвлөлтийн занал» гэдэг гүжир гүтгэлгийн цоорхой шүхрийн дор Вашингтон, Бээжин сүүлийн үед Токио үг хэлээ нийлүүлэн орцгоох боллоо. Японы ерөнхий сайд Я. Накасонэг Бээжинд энэ оны 3-р сард айлчлах үеэс Хятадад гол заналыг ЗХУ учруулж байгаа мэтээр ойлгуулаад Японтой Хятад энэ зуунд байтгауй ирэх зуунд байлдахгүй тухай хэлцээ хийлээ. Гэтэл Японы усан хилийн батлан хамгаалах заагийг 1000 миль болгож өргөтгөх тухай асуудлыг Индонез, Филиппин зэрэг орнууд дэлхийн хоёрдугаар дайны үед Японоос Зүүн өмнөд Азид учруулсан гашуун туршлага дахин давтагдаж болох эгзэгтэй гэж үзэж байна.

Эргэн тойрны байдал ийм байхад Зүүн өмнөд Азийн орнууд гар мухар суухыг бодохгүй нь мэдээж юм. Лондоны стратеги судлалын олон улсын институтын тооцоолсноор АСЕАН-ы таван орон 1982—1983 онд цэргийнхээ зардлаас 8,2 миллиард доллар зарцуулсан нь 1978 оны нэгдсэн зардлаас 70 гаруй хувь нэмэгджээ.

Эдгээр байдлыг бүхэлд нь аваад үзэхэд хятадын бодлого Зүүн өмнөд Азийн энх тайван, аюулгүй байдалд нааштай хувь нэмэр оруулж байна уу, уршиг тарьж байна уу гэдэг нь тодорхой харагдаж болох юм. Зүүн өмнөд Ази дахь өнөөгийн байдлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн эс шийдвэрлэвэл уг байдал даамжирч Зүүн өмнөд Азид хятад ихээхэн хэмжээний дайн үүсгэх аюулд хүргэж болзошгүй гэдгийг Вьетнам, Лоасын удирдагчид сануулсаар байна.

Ардчилсан Кампучийн эвслийн засгийн газрын тэргүүн гэгч Нородом Сианук 1984 оны 2, 3-р сарын дундуур АСЕАН-ы 5 орноор явж Кампучаас Вьетнамын цэрэг гарах хүртэл кампучийн ард түмэн Вьетнамын эсрэг тэмцлээ үргэлжүүлэх бөгөөд энэ нь Кампучийн үндэсний сонирхолтой тохирч байгаа мэтээр ойлгуулахыг оролдсон юм. Түүгээр барахгүй Бүгд Найрамдах Кампучи Ард Улсын бүрэн эрхийг үгүйсгэж хэрэв Вьетнам Кампучаас цэргээ гаргавал Ардчилсан Кампучи Вьетнамтай энх тайван, харилцан үл түрэмгийлэх ба найрамдалын гэрээ байгуулж гарын үсэг зурахад бэлэн байна<sup>8</sup> гэж өгүүлсэн нь хэрэг дээрээ Энэтхэг-Хятадын хойгийн эмзэг тогтворгүй байдлыг хэвээр үргэлжлүүлэхэд хүргэхээс биш ямар нэгэн нааштай шинэ санал биш юм. Хамгийн гол нь энэ саналын цаана хэн зогсож байгаа нь илэрхий байна.

Кампучийн асуудал гэгчийг анх сэдэж гаргасан нь Хятад бөгөөд ингэж асуудал үүсгэхийн шалтгаан нь Энэтхэг-хятадын хойгийн гурван оронд ноёлох гэсэн хятадын «уламжлалт» «удаан хугацаа»-ны санаархалтай холбоотой юм. Иймээс ганц Вьетнамд биш, энэтхэг-хятадын хойгийн гурван оронд бүхэлд нь хятад аюул занал

бол түүхийн өнөө үед «байнга» оршиж байна. БНСВУ-ын ГЯЯ-ын 1984 оны 4-р сарын 9-ний мэдэгдэл ч үүний шинэхэн нотолгоо болно. Уг мэдэгдлээс үзэхэд хятадын тал энэ оны 4-р сарын эхээр Вьетнамын хил орчмын 6 мужийн суурин газар, аж ахуйн байгууламжуудыг их буугаар тасралтгүй буудаж, зарим өндөрлөгийг эзлэн авах зорилгоор хэд хэдэн батальон явуулсан байна. Энэ ялт ажиллагаа нь энх тайвны тухай ярьдаг мөртлөө бодит хэрэг дээрээ энэтхэг-хятадын хойгийн гурван орны ард түмний эсрэг хорлон сүйтгэх дайныг хүчтэй болгож байгаа Бээжингийн эрх баригчдын жинхэнэ нүүр царайг ил тодорхой илчлэн харуулж байна гэж уг мэдэгдэлд заажээ.<sup>9</sup>

АСЕАН-ы орнуудаас Зүүн өмнөд Азид энх тайван, эрх чөлөө, төвийг сахих бүсийн бодлого буюу «зопфан»\*-ий үзэл санааг дэвшүүлж уг бүс нутгийн байдлыг эрүүлжүүлэх асуудалд санал санаачлага гаргасаар ирсэн юм.

АСЕАН-ы гишүүн Индонез зэрэг орны зарим удирдагчид «Вьетнамын занал» гэгч хэрэг дээрээ зохиомол зүйл гэдгийг ойлгож байна. АСЕАН болоод Энэтхэг-хятадын хойгийн орнуудын харилцааг сайжруулж уг бүс нутгийн улс төрийн уур амьсгалыг бүхэлд нь тогтворжуулахад АСЕАН-ы орнуудын идэвхи чармайлт чухал ач холбогдолтой нь мэдээж билээ. Иймд үзэл санааны нэг тод илрэл бол АСЕАН-ы байнгын хорооны одоогийн дарга, Индонезийн гадаад явдлын яамны сайд Мохтар Кусумаатмажа Москвад айлчлсан тухай Зөвлөлт, Индонезийн 1984 оны 4-р сарын 5-ны хамтарсан мэдэгдэл болно. Түүнд заахдаа хоёр тал Зүүн өмнөд Азийн байдлыг хэлэлцээний замаар зохицуулж, тус тус нутагт энх тайван тогтвортой байвал ханган тогтоох саналтай байгаагаа илэрхийлжээ.

Зөвлөлт, Индонезийн хэлэлцээний явцад Энэтхэг-хятадын хойгийн улсууд, АСЕАН-ы орнуудын хооронд үр бүтээлтэй яриа хэлэлцээ хийх нь Зүүн өмнөд Азийн бүс нутгийн байдлыг түргэвчлэн сайжруулж, шийдвэрлэглээгүй асуудлыг эв зүйгээр зохицуулах зорилтыг хангах цорын ганц ухаалаг арга зам мөн гэж зөвлөлтийн тал тэмдэглээд Вьетнам, Кампучи, Лаосын ГЯЯ-ны сайд нарын 8-р бага хурлаас дэвшүүлсэн тодорхой санаачлага нь үр бүтээлтэй яриа хэлэлцээ хийх сайхан үндэс бүрдүүлж байгааг заажээ.

Хятадын удирдагчид АСЕАН-ы гишүүн орнууд болон энэтхэг хятадын хойгийн орнуудын хоорондын харилцааг хурцатгаж, уг бүс нутгийн эвдрэл хямралын уур амьсгалыг даамжруулахыг хичээж байгааг 1983 оны 12-р сард Кампучийн «эвслийн засгийн газрын» толгойлогчдыг хятадын эрх баригчид Бээжинд хүлээн авч хятад улс кхмерийн харгис этгээдүүдэд хойшид ч дэмжлэг үзүүлэх тухайгаа амалсан явдал<sup>10</sup> нотолсон юм. Энэ бол энэтхэг-хятадын хойгийн орнуудын талаар хятадын явуулж байгаа дайсагнасан бодлого өөрчлөгдөөгүй бөгөөд энэтхэг-хятадын хойгоор зогсохгүй нийт Зүүн өмнөд Азийн энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байгааг дахин харуулсан юм. Гэвч АНУ тэргүүтэй империалист хүчний дайнч бодлогын уршгаар дэлхий дахинд түүний дотор дэлхийн хүн амын тэн хагас шахам нь оршин суудаг Ази тивийн улс хоорондын харилцаа нэн ноцтой болсон өнөө үед энэ тивийн энх тайван, аюулгүй байдлыг бататгах интернационалч үйлсийг ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орнууд хойшуучилж байна.

<sup>9</sup> «Үнэн» 1984. IV. 10

\*Зопфан (Энх тайван, эрх чөлөө, төвийг сахих бүс)

<sup>10</sup> «Жэньминь жибао» 1983. XII. 25

Ийм нөхцөлд БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох нь олон улсын амьдралд социализмын ролийг дээшлүүлэхэд тус дөхөм болох ёстойг ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нөхөр Константин Черненко тэмдэглээд харин: «бид гурав дахь улс орныг хохироох замаар хэлэлцэн тохирохыг зөвшөөрөхгүй. Гэвч санал солилцох явдал үргэлжилж байгаа бөгөөд бид үүнийг ашигтай гэж үзэж байна. Зөвлөлт Холбоот Улс хоёр этгээдийн хүлээн авч болох хэрээр харилцааны хэмжээг дээшлүүлэхийн төлөө байна»<sup>11</sup> гэж мэдэгдсэн билээ. Энэ бол ЗХУ-ын тууштай энх тайванч, интернационалч гадаад бодлогын бас нэг тод илрэл бөгөөд ийм бодлого бол дэлхийн нийт улс түмний амин чухал эрх ашиг, түүний дотор хятадын олон зуун сая ард түмний эрх ашигт нийцэх болно. Гагцхүү Бээжингийн удирдлага их гүрний жанжлах, дээрэнгүй бодлогоо хир зэрэг түргэн таягдан орхиж социализмын бүх орнууд, Ази, Африк, Латин, Америкийн тусгаар тогтносон орнуудтай хамтран империализмын эсрэг, дэлхийн шинэ дайны эсрэг тууштай бодлого явуулахаас Хятадын олон улсын нэр хүнд төдий чинээн түргэн дээшилж, чингэснээр Ази болон даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын төлөө тэмцэлд бодит хувь нэмэр оруулж чадах юм.

## **ПОЛИТИКА КИТАЯ В ЮГО-ВОСТОЧНОЙ АЗИИ В ПРОШЛОМ И НАСТОЯЩЕМ**

**(Резюме)**

**Э. Пунцаг  
Ч. Сувд**

Народы Индокитая приобрели настоящую свободу и независимость от империализма и колониализма, только благодаря расширению национально-освободительного движения на Востоке, начало которому было положено победой Великой Октябрьской социалистической революции в России.

Крупным успехом революционного движения в Азии во второй половине 70-х годов явилось провозглашение в 1975 году Лаоской Народно-демократической республики, в 1976 году Социалистической республики Вьетнам, а в 1979 году Народной Республики Кампучия. Формирование и укрепление союза народов Вьетнама, Лаоса и Кампучии за весь период истории их совместной борьбы за свободу и независимость показали закономерность революционного процесса в этом регионе.

Однако, на нынешнем этапе революционного развития в этом районе Азии, силы империализма и гегемонизма всячески препятствуют их народно-демократическому социалистическому строительству. Особую роль в этом играет внешняя политика Китая, которая на протяжении многих веков была направлена на подрыв процесса исторического развития в этих странах. Политику маоистского руководства КНР в от-

<sup>11</sup> К. Черненко. Ард түмэн, нам хоёр нэгдмэл, (Сонсогчдын өмнө хэлсэн үг) «Үнэн» 1984. III. 4

ношении этих стран отличает ее приемственность от основанной китаецентризме», традиционной внешней политики феодального Китая, о чем свидетельствует вооруженное вторжение китайских воинских частей в 1979 году во Вьетнам. Однако неправильно объяснять подобную акцию. Пекина лишь обыкновенным продолжением политики древнекитайских императоров, проводимую в новых условиях и под новым предлогом.

Аналогичное мнение по этому поводу разделяют и зарубежные китаеведы. В качестве примера авторы ссылаются на работы проф. К. Н. Фитцджеральда (Австралия), проф. Р. С. Чавана (Индия).

Отказавшись от совместной борьбы социалистических стран против империализма, нынешнее руководство КНР по ряду вопросов внешней политики занимает позицию общую, параллельную или сходную с американским империализмом, враждебно относясь к развитию стран Индокитая по пути прогресса и социализма.

Китайские войска и поныне продолжают вторгаться на территорию Вьетнама, подвергают массированным артиллерийским обстрелам его пограничные города и села. Пекин упорно отказывается от нормализации двухсторонних отношений с СРВ и одновременно навязывает странам АСЕАН политику конфронтации с Вьетнамом, Лаосом и Кампучией в то время, как они неоднократно выступали за переговоры.

В заключение, авторы констатируют, что в общем и целом политика Китая в ЮВА несет в себе характер постоянной угрозы, чреватой опасностью для всей Юго-Восточной Азии. Лишь отказ Пекина от своей экспансионистской внешней политики может содействовать превращению ЮВА в зону мира, стабильности и сотрудничества, что отвечает интересам народов континента, в том числе интересам китайского народа.